

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 03 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1 удаа хуралдаж 9 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Журам батлах тухай /Сумдын төвийн шинэчлэл-Хөдөөгийн хөгжил төслийн хүрээнд баригдах 120 айлын орон сууц барих газрын эрх олгох, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах журам/

2. Журам батлах тухай /Газар тариалан, жимс, жимсгэнэ төслийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих журам/

3. Төрийн өмчид хөрөнгө шилжүүлэхийг зөвшөөрөх тухай

4. Хөрөнгө балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрөх тухай

5. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам батлах тухай

6. “Алтай орон сууцны корпораци” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

7. “Алтай орон сууцны корпораци” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын бүтэц, албан тушаалын тодорхойлолт, цалингийн жишгийг шинэчлэн батлах тухай

8. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланг дэмжин батлах тухай

9. “Эхийн алдар” одон нөхөн олгуулах тухай зэрэг болно.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Прокурорын газар хамтран авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг бууруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилготой "СУДАЛЪЯ, МЭДЬЕ, СЭРГИЙЛЬЕ" нөлөөллийн аяны нээлтийг 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан бөгөөд аяны үйл ажиллагаанд тус аймгийн Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн өмчит байгууллагууд хамрагдаж, үйл ажиллагааг зохион байгуулна.

“Сумдын удирдах ажилтны анхдугаар зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, хууль эрх зүйн мэргэжилтнүүд, нийт 80 албан хаагч оролцож, мэдлэг чадвараа дээшлүүлж, мэдээлэл авлаа.

Аймаг хөгжүүлэх болон тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ирүүлсэн шинэлэг санаа, санаачилгыг дэмжиж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор долоо хоног бүр “Шинэ санаа” арга хэмжээг аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудаас авч судлан, үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

Аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнийг 03 дугаар сард “Өглөөний цай” хэлбэрээр 4 удаа зохион байгуулж, аймгийн удирдлагууд цаг үеийн мэдээлэл хийж, үүрэг чиглэл өгөхийн зэрэгцээ аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 6

агентлаг үйл ажиллагаагаа сурталчилан цаашид хийх ажлынхаа төлөвлөгөөг танилцууллаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны Үндэсний хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх тухай 01 тоот албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй 60 төрийн байгууллагад хуваарийн дагуу ажиллаж, зөвлөгөө, чиглэл өглөө.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлого, зорилтыг сумын хэмжээнд хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай 2021 онд хамтран ажиллах гэрээг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр байгууллаа.

Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид байгаль орчин, аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид анхаарах асуудлаар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шуурхай баг Дэлхийн байгаль хамгаалах сангаас 2021 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээг танилцуулж, цаашид хамтран ажиллах чиглэлээр тус тус цахим уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг давхардсан тоогоор 13 байгууллагын албан хаагчид оролцож, мэдээлэл солилцлоо.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдсан 3 удаагийн цахим сургалтад салбар зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагийн холбогдох албан тушаалтнууд хамрагдлаа.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ сэдэвт Удирдлагын академийн богино хугацааны сургалтад аймгийн Засаг даргын дэргэдэх 23 агентлагийн 46 албан хаагч суралцаж, төгслөө.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2021 оны 03 дугаар сарын 12, 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулж, бүртгүүлсэн 316 иргэнээс 271 буюу 85.7 хувь нь шалгалт өгснөөс 116 иргэн буюу 42.8 хувь нь тэнцэж, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 106 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдлээ. Энэ удаагийн шалгалтын онцлог нь шалгалтад оролцогчдыг Төрийн албаны зөвлөлөөс zoom программаар хянаж, камераар баримтжуулан, Улсын бүртгэлийн хэлтсээс хурууны хээгээр бүртгэж орууллаа. Мөн шалгалтын ил тод байдлыг ханган шалгуулагч иргэд болон сонирхсон этгээдэд шалгалтын үйл явцыг дэлгэцээр хөндлөнгөөс ажиглаж, хяналт тавих боломжтойгоор зохион байгуулсан болно.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 03 дугаар сарын 30-ны өдрийн Засаг даргын зөвлөлийн 14 дүгээр хурлаар хэлэлцүүлэн, 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/412 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (unelgee.gov.mn)-д заалт тус бүрээр байршууллаа.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын төслийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/111 дүгээр захирамжаар батлууллаа. Батлагдсан журмыг хэлтэс, сум, агентлагийн төрийн албан хаагчдад e-office программаар хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумдын удирдлагууд болон Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтнүүдэд 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын талаар мэдээлэл хүргэж, харилцан санал солилцлоо.

Хэрэгжүүлэх хугацаа дуусаагүй дэд хөтөлбөрүүдэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ.

Тайлант хугацаанд Үйлчилгээний нэгдсэн төв нь иргэдээ сонсох нээлттэй утас 70481111, мэдээлэл лавлагааны E-Mongolia цахим үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Архивын тасаг, Наториатын үйлчилгээгээр нийт 162 нэр төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 1963 иргэн, хуулийн этгээдэд нэг цэгээс түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэн ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 17 өргөдөл ирснээс 7 өргөдлийг шийдвэрлэж, 10 өргөдөл нь хяналтын шатандаа, хугацаандаа судлагдаж байна. Шийдвэрлэлт нь 41.18 хувьтай байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 14 хоног байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 03 дугаар сарын байдлаар нийт 34 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгч e-office программд бүртгэгдсэн 25 гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, холбогдох байгууллагуудад шилжүүлэн хяналт тавин, шийдвэрлүүлэн ажиллалаа. Хугацаандаа судлагдаж байгаа 12 өргөдөл, шийдвэрлэлт 48.0 хувьтай байна.

E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системээр нийт 54 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд хүргэх боломжтой бөгөөд тайлант хугацаанд 9 төрлийн цахим мэдээллийн үйлчилгээг 179 иргэнд төлбөртэй, 40 иргэнд төлбөргүй, нийт 219 лавлагаа мэдээлэл гаргаж үйлчилсэн ба үйлчилгээний хураамж 498.0 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүллээ.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Тайлант хугацаанд 10 сумын 73 захирамжийг хянаж, эрх зүйн үндэслэл зөрчилтэй захирамж тус бүрт зөвлөмж өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/78 дугаар захирамжаар баталсан “Гэрээг хянах, бүртгэх” журмын хүрээнд Засаг даргын Тамгын газраас байгуулсан 3 гэрээг хянан, бүртгэж, гэрээнд тусгах саналыг хүргүүллээ.

Гэрээний харилцаанаас үүсэх маргаан, аливаа хэлбэрийн хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор гэрээний гүйцэтгэл, үр дүн, чанарт тогтмол хяналт тавин гэрээний үүргийг биелүүлээгүй, хугацаа дууссан үед алданги тооцох, гэрээ цуцлах, хугацаа сунгах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд хандах зэргээр хууль тогтоомжид заасан бусад ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллах тухай чиглэлийг сумдын Засаг дарга, агентлагийн дарга нарт хүргүүлж, гэрээний хэрэгжилтийн талаар судалгаа хийж байна.

Нийтийн албанд томилогдох 7 хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, Авлигатай тэмцэх газраас ирсэн дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар томиллоо.

Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран сумдын эрх зүйн хөтөч нарт цахим сургалтыг 03 сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулж, чадавхжууллаа. Тус сургалтад нийт 44 хүн хамрагдлаа

Төрийн албаны зөвлөлд нэр бүхий 3 хүний гомдлыг шалган шийдвэрлэхэд шаардлагатай баримт, тайлбарыг бүрдүүлэн нотлох баримтын шаардлага ханган хүргүүлж, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 63 дугаар тогтоолыг хүчингүй болгох нэхэмжлэл гаргасан.

Иргэний хэргийн шүүх хуралд 2 удаа оролцож, 2 иргэний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч нарыг томилж, хариу тайлбарыг гаргалаа.

Аймгийн хэмжээнд ажлаас хууль бусаар чөлөөлсөн, үндэслэлгүй халагдсан буюу хөдөлмөрлөх эрхтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн маргааны улмаас төрд учирсан хохирлыг барагдуулахаар Прокурорын газраас шүүхэд хандаж нэхэмжлэл гаргах ажлыг зохион байгуулах гэж байгаатай холбогдуулан нотлох баримтыг бүрдүүлэх ажлыг хийж байна.

Архивын тасаг: Архив,албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нэмэгдэх орон тооны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулж, мэргэжил арга зүйн зөвлөмж авахаар Архивын газарт уламжиллаа.

Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 104 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар нийт 1660 хуудас бүхий лавлагаа олгож, 1.5 сая төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүллээ.

Чандмань сумын Үүрийн туяа нэгдлийн 30 хадгаламжийн нэгжид иж бүрэн шалгалт хийж, Бигэр, Халиун сумын 1970 оны иргэний үнэмлэх олголтын бүртгэлийн 2 хадгаламжийн нэгжийн 184 хуудас баримтыг сэлбэн засч, Тонхил, Жаргалан, Дэлгэр, Бигэр сумын 38 хадгаламжийн нэгжийн 20628 хуудас бүхий 24005 хүний нэрийг цахим хэлбэрт орууллаа.

Улсын бүртгэлийн хэлтэс: Иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд явуулж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж ажиллалаа.

Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн 335 лавлагааг гаргаж, 27 иргэний гадаад паспортын захиалга хүлээн авч, 16 хуулийн этгээдийг шинээр, 18 хуулийн

этгээдийг дахин бүртгэн гэрчилгээ олгож, бүртгэлийн цахим мэдээллийн санг тухай бүр баяжуулж байна.

Иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 699 мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн, бүртгэлийн үйлчилгээний хураамж 129.3 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 19.7 сая, татварын орлого 2.4 сая, нийт 151.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүллээ.

Тайлант хугацаанд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж 12 иргэнд 0.4 сая төгрөгийн торгууль ногдуулж, иргэний бүртгэлийн чиглэлээр 9, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 4, хуулийн этгээдийн чиглэлээр 1, нийт 14 дүгнэлт гаргаж, зөрчлийг арилгууллаа.

Шүүхийн шинжилгээний алба: Тайлант хугацаанд шүүх эмнэлгийн 44 шинжилгээ хийснээс хүний биед гэмтлийн зэрэг тогтоох 34, хүний биед хийсэн бусад 1, цогцост 8 шинжилгээ хийсэн бөгөөд гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээгээр хүнд 1, хүндэвтэр 1, хөнгөн 7, гэмтлийн зэрэгт хамаарахгүй 12, гэмтэл тогтоогдоогүй 13 байна.

Эрүүгийн хэргийн 14 тусгай шинжилгээ хийснээс химийн 9, биологийн 5 шинжилгээ хийж, мөрдөн шалгах бусад ажиллагаанд 8 удаа оролцож, 264 гэрэл зургийн ажил хийлээ.

Мөн эрүүгийн 15 хэрэгт 13 объектод 7 криминалистикийн шинжилгээ хийж, хэргийн газрын үзлэгт 26 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 7, хулгай 3, хүчин 1, зам тээврийн ослын 7, бусад 8 хэрэгт үзлэг шинжилгээ хийж, хэргийн газрын үзлэгээр 66 ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, баримтжуулан ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: Өмнөх оны үлдэгдэл 2116.7 сая төгрөгийн 272 гүйцэтгэх баримт бичиг болон шүүхээс шинээр 417.8 сая төгрөгийн 108 гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч, 4 гүйцэтгэх баримт бичгийн 163.4 сая төгрөгийг төлбөр авагчийн хүсэлтээр буцааж, 3 гүйцэтгэх баримт бичгийн 15.9 сая төгрөгийг газар хооронд харьяаллын дагуу шилжүүлж, үлдэгдэл 373 гүйцэтгэх хуудасны 2355.0 сая төгрөгийг биелүүлэхээс 92 гүйцэтгэх баримт бичгийн 353.8 сая төгрөгийн гүйцэтгэх баримт бичгийг биелүүлж, үлдэгдэл 281 гүйцэтгэх баримт бичгийн 2001.3 сая төгрөг байна. Тайлант хугацаанд хэрэгжилт 24.6 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.0 хувиар, улсын дундажтай харьцуулахад 8.9 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Цагдаагийн газар: Тайлант хугацаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 36 дуудлага мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 11 өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авч хуулийн хугацаанд шалгаж байна.

Замын цагдаагийн тасаг давхардсан тоогоор 305 тээврийн хэрэгсэл шалгаж, 153 зөрчил илрүүлэн, 146 хүнд 4365.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 6 зөрчил илрүүлэн, 4 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 2 жолоочийг баривчилж, эрхийн үнэмлэхгүй

тээврийн хэрэгсэл жолоодсон 1 зөрчил илрүүлэн шалгаж, 7 тээврийн хэрэгслийг түр саатуулсан байна.

Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт гарч болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөр бүр 24.00 цагаар, давхардсан тоогоор 7 автомашин, 14 алба хаагч, 14 олон нийтийн цагдаа ажиллаж баар, үйлчилгээний газар, дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийн үйл ажиллагаанд хяналт тавин, 254 иргэн, 64 тээврийн хэрэгсэл шалгаж Зөрчлийн тухай хуулиар 39 иргэнийг 970.0 сая төгрөгөөр торгож, иргэд байгууллагаас зөрчлийн шинжтэй 9 дуудлага мэдээлэл хүлээн авч, гудамж талбай олон нийтийн газар согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн биеэ авч явах чадваргүй 4 иргэнийг ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, эрүүлжүүлэх саатуулах байранд 3 иргэнийг эрүүлжүүллээ.

Аймгийн цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Тайшир сумын болон Баянхонгор аймгийн Бууцагаан сумд байрлах байнгын хяналтын пост, аймгийн төвийн Замын цагдаагийн хяналтын 2 пост, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хяналтын пост, шуурхай удирдлагын штабын байранд тус бүр нэг албан хаагчийг ээлжлэн ажиллуулж, гэрийн ажиглалтад байгаа иргэдэд хяналт тавих чиглэлээр 13 алба хаагчийг ажиллуулж байна.

Эрүүгийн хэргийн шүүх, хуралдааны аюулгүй байдлыг ханган ажиллаж эрүүгийн 5, иргэний 4, захиргааны 6, нийт 15 хэргийн шүүх хуралдааны дэгийг сахиулж, шүүгч болон оролцогч нарын аюулгүй байдлыг ханган ажиллалаа.

Сургалт сурталчилгааны чиглэлээр хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 фостор, зурагт хуудсыг хийж цахим хуудаст байршуулан иргэдэд түгээж, “Хүүхэд хамгаалал” арга хэмжээг зохион байгуулж, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд 90 иргэнд сургалт мэдээлэл хийж, зөвлөмж, сэрэмжлүүлэг 450 ширхэгийг бэлтгэн, хүргэлээ.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн төсөвт 1790.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1934.5 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 108.0 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 416.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 499.8 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 120.0 хувиар тус тус биелүүллээ. Орон нутгийн төсвийн байгууллагуудад 1114.1 сая төгрөг, сумдад 487.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 4034.8 сая төгрөгийг тус тус хуваарийн дагуу бүрэн олголоо.

Орон нутгийн хөгжлийн сан эхний 03 сарын байдлаар 625.7 сая төгрөгийн санхүүжилтийн төлөвлөгөөтэй бөгөөд 120.1 сая төгрөгийн санхүүжилт ирж 19.2 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааны чиглэлээр: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд 7875.5 сая төгрөгийн 55

төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас 41.8 хувийн хэрэгжилттэй байна.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 23 төсөл арга хэмжээг цахим системээр зарлаж, давхардсан тоогоор 72 аж ахуй нэгж оролцож, 7 аж ахуй нэгж гүйцэтгэгчээр шалгарсан.

3 аж ахуй нэгжид тоон гарын үсгийг баталгаажуулж цахим тендерт оролцох боломжийг нь бүрдүүлж өгснөөр тендерт оролцож, цаг хугацаа, зардлаа хэмнэх бүрэн боломжтой болсон.

“Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв” ТББ-тай хамтран 18 сум, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл 106 иргэнийг хамруулан зохион байгуулснаас 62 иргэн тэнцэж, А/3 гэрчилгээ эзэмшин, үнэлгээний хороонд ажиллах эрхтэй боллоо..

Өмчийн асуудлаар: “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”, гэрээний загварын төслийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.

“Ундарга-Алтай”, “Гэгээн нуур-Цэвэр ус” ААТҮГ-уудын үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөг хянаж, Засаг даргын Зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлээд байна.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Зорилтот сумдын малчдад 1107 тн хүчит тэжээл хүргэлээ.

Дэлхийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслөөс Бигэр, Бугат, Дэлгэр, Тонхил, Төгрөг, Халиун, Чандмань, Цогт, Цээл Эрдэнэ сумын (10 сум) 4276 малчин өрхөд олгосон 1107 тн буюу 1.1 тэрбум төгрөгийн хүчит тэжээлийг татан авч малчдад хүргэх ажлыг зохион байгууллаа.

2021 оны тариалалтад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, үрийн хэрэгцээг гаргалаа.

Газар тариалан жимс, жимсгэнэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд сумдын тариалангийн талбай, техник, тоног төхөөрөмж, ажиллах хүч тэдгээрийн зохион байгуулалт, услалтын системийн ашиглалтын өнөөгийн байдал, цаашид хэрхэн сайжруулах талаарх судалгаа болон 2021 оны тариалалт хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, үрийн хэрэгцээг гарган худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

Бизнес эрхлэгчдэд сургалт зохион байгууллаа.

Сум хөгжүүлэх сангийн мэдээлэл, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн мэдээлэл, зээлийн батлан даалтын сангийн талаарх сургалтыг 3 дугаар сарын 3-ны өдөр, ажлын байрыг дэмжих 3 хувийн хүүтэй зээлийн талаарх мэдээллийг 3 дугаар сарын 10-ны өдөр тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 127 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж, мэдээлэл авлаа.

Төл бойжилт 97.7 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 18 сумын 88 багийн 7915 малчин өрхөд 3310.8 мянган толгой мал хаваржиж, төллөвөл зохих 864.6 мянган хээлтэгчээс 170.6 мянган мал төллөж, 166.7 мянган толгой төл бойжиж байна. Аймгийн хэмжээнд том малын хорогдол 86.1 мянган толгой буюу нийт малын 2.6 хувь нь хорогдоод байна.

Бугат, Тонхил, Дарив, Тайшир, Цээл, Цогт, Чандмань, Есөнбулаг /8/ сумын малчдад олгогдсон арьс ширний урамшууллын мэдээллийг системийн мэдээлэлтэй тулгалаа.

Мал эмнэлгийн чиглэлээр: 1609 малын сэг зэмийг устгаж, ариутгал халдваргүйтгэл хийлээ.

Аймгийн Засаг даргын А/107 дугаар захирамжийн дагуу малын сэг зэм устгах, халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан сумдад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт 1609 малын сэг зэмийг устгаж, 4716 м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийгээд байна. Сэг зэм устгахад шаардагдах хөрөнгө санхүүгийн тооцооны саналыг Улсын онцгой комисст хүргүүлснээр сумдын мал эмнэлгийн нэгжүүдэд 16.2 сая төгрөгийн 560 ширхэг халдвар хамгааллын иж бүрэн хувцас, 10.2 сая төгрөгийн 390 кг ариутгал халдваргүйтгэлийн бодисыг нийлүүлээ.

“Шинэ-Алтай” хүнсний захад үйл ажиллагаа явуулж буй мах сүүний дэлгүүрүүдэд мал эмнэлгийн магадлан шинжилгээний гэрчилгээг цахимаар олгож эхэллээ.

“Тархварзүйчдын холбоо”-ноос зохион байгуулсан цахим сургалтад 18 сумын тархварзүйч, мал эмнэлгийн газрын 5 мэргэжилтэн, нийт 23 албан хаагч хамрагдлаа.

Шарга сумд тэмээний, Дарив сумд нохойн, Жаргалан сумд үхрийн галзуу, Тайшир, Эрдэнэ сумд ямааны хамуу, Шарга сумд ямааны, Есөнбулаг сумд үхрийн цусан халдвар өвчин оношлогдож холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Мал эмнэлгийн лаборатори 2 жилээр итгэмжлэгдлээ.

Стандарт хэмжил зүйн үндэсний Итгэмжлэлийн газраас 3 сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан Мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагааг шалгах итгэмжлэлийг сунгах онлайн шалгалтад аймгийн Мал эмнэлгийн лаборатори хамрагдан ажиллах хугацаа нь 2 жилээр сунгагдлаа.

ТАВ. БАРИЛГА ХОТ БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд: Сумдад барих 15 айлын орон сууцны нэг маягийн давтан хэрэглэх барилгын зургийг “Тоонот констракшн” ХХК-аар гүйцэтгүүлэн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 178/2021 дугаар магадлалын дүгнэлтээр, барилгажих талбайн инженер геологийн хөрсний шинжилгээг “Барнаб” ХХК-аар 2021 оны 03 дугаар 02-ны өдрөөс 03 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгүүлэн магадлалын дүгнэлтээр баталгаажуулан хүлээж авлаа.

Мөн сумдад баригдах 120 айлын (15 айлын 8 блок) орон сууцны барилга болон Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Тонхил, Төгрөг, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмань,

Шарга сумдыг халаалтын нэгдсэн шугам сүлжээнд холбох, уурын зуухны барилга барих ажлыг хувийн хөрөнгө оруулалтаар “Барих-ашиглах-шилжүүлэх” нөхцөлтэйгөөр гүйцэтгэх аж ахуй нэгж байгууллагуудын саналыг авахаар нийтэд мэдээлээд байна.

Газрын харилцааны чиглэлээр: Газрын үнэлгээний системд газар эзэмших эрх шилжүүлсэн, эрхийн гэрчилгээгээ худалдан борлуулсан нийт 23 иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг системд бүртгэлээ.

2020 оны газрын төлбөрийн тооцоог 17 иргэн, 5 аж ахуйн нэгж байгууллагын 61 нэгж талбарт хийж, 2021 оны газрын төлбөрийн нэхэмжлэлийг хүргүүлэв.

Газар эзэмшигчийн татвар төлөгчийн дугаар татагдаагүй 526 иргэний мэдээллээс татварын хэлтэстэй тулгалт хийж 103 газар эзэмшигчийн татвар төлөгчийн дугаарыг татаж, 90 газар эзэмшигчийн газрын нэхэмжлэлийг газрын төлбөрийн системээр үүсгэж дундын хур мэдээллийн санд илгээсэн.

Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжийн хэрэглээний түвшинд ажиллах эрхийн гэрчилгээ олгохтой холбогдуулан сумдын газрын даамлуудад тус программ хангамжийн сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 5-ны өдрүүдэд зохион байгуулж, Баян-Уул, Цогт, Чандмань, Дарив, Тайшир сумд газрын даамал, газар зохион байгуулагч мэргэжилтэй 2, нийт 7 иргэнийг хамрууллаа.

Газар эзэмшигч 1 байгууллага, 3 иргэний байршлын кадастрын зураг гаргаж, газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагааг www.egazar.gov.mn сайтаас гаргаж 6 иргэнд үйлчилсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/45 дугаар захирамжаар байгуулсан “Газар зүйн нэрийн салбар зөвлөл” хуралдаж, баг, тосгоны нэрийн зөрчлийг арилгуулж, 18 сумын 86 баг 2 тосгоны нэрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр: Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүр хөтлөлтийн тайланг гарган Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт албан бичгээр хүргүүллээ.

Хувийн хөрөнгө оруулалтаар Хөхморьт сумд баригдах “Түрлэг уст” ХХК-ийн ШТС-ийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар гаргалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Есөнбулаг сумын 3, 5, 8 болон Чандмань сумын цэцэрлэг, Төгрөг сумын сургууль, Эрдэнэ, Дэлгэр сумын соёлын төвийн засвар, Уламжлалт анагаах ухааны төвийн засварын ажлуудын зургийн даалгаврыг боловсруулав.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан боловсролын салбарын хөрөнгө оруулалтын www.investment.edu.mn цахим системийн танилцуулга сургалтад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрын 3 албан хаагч хамрагдлаа.

Аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр болон хувийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжсэн барилга байгууламжийн нормчлолын

сангийн шимтгэл 5.6 сая төгрөгийг Худалдаа хөгжлийн банкны 2600078533 дансанд төвлөрүүлээ.

Хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан иргэн Л.Нанжидын үйлчилгээний төвтэй 16 айлын орон сууц, "Өргөө засал" ХХК-ийн 30 айлын орон сууц, "Наяд натур" ХХК-ийн мал төхөөрөх цехийн барилгад улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад орууллаа.

Барилгын материалын чиглэлээр: Есөнбулаг сумд баригдах "Хан Алтай Ресурс" ХХК-ийн уурхайн 400 хүний кемпийн барилга угсралтын ажлын холбогч материал болох цементийн 2 дээж, бетон сорьцын дээжийг хүлээн авч шинжилгээнд хамрууллаа.

Нийтийн аж ахуйн талаар: "Ундарга-Алтай" ААТҮГ 5 гүний худаг, 1 нөөцийн худагтайгаар үйл ажиллагаагаа явуулж, Алтай хотын ард иргэдэд 46139 м³ ус олзворлон түгээсэн байна.

2 дугаар өргөлтийн насос станцын хувьд 2 насос (№2,3), 1 нөөцийн (№1-р насос) насостойгоор үйл ажиллагаагаа явуулж, 40894.4 м³ усыг даралтат усан санруу шахсан.

Цаг агаарын аюулт үзэгдэл шороон шуурганаас болж цахилгаан дамжуулах агаарын шугамд тасралт үүссэн зэрэг бусад шалтгаанаас үүдэн 12 удаагийн 669 минутын цахилгааны саатал гарсан бөгөөд техникийн зохицуулалтаас үүдэн 8 удаагийн 825 минутын зогсолт хийсэн.

Цэвэрлэх байгууламжид 41144.4 м³ бохир хүлээн авч цэвэршүүлж, 6.3 м³ усанд уусаагүй хольц буюу овор хэмжээ ихтэй хог хаягдлыг татан зайлуулсан. Тунгаагуураас 101.6м³ лаг, 0.8м³ элс шороог зайлуулан хатаах талбайд хаяж, ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

Албан байгууллагаас-29, айл өрхөөс-90 дуудлагыг хүлээн авч, цэвэр усны шугам сүлжээ, тоног төхөөрөмжтэй холбоотой 22, бохир усны шугам сүлжээ, тоноглолтой холбоотой 97 дуудлагыг бүрэн шийдвэрлэсэн.

Дэд бүтцийн салбарт: Цахилгаан эрчим хүчний хангамж:
Цахилгаан эрчим хүчний их ачаалал 17.9 МВт, бага ачаалал 9 МВт хүрсэн бөгөөд

Төвийн бүсийн нэгдсэн систем 14.5 МВт, Баруун бүсийн эрчим хүчний систем 0.6 МВт, Тайширын УЦС 2.0 МВт, Есөнбулаг Дизель станц 0.6 МВт чадалтай оройн оргил ачаалалд ажилласан байна. Нийт хэрэглээний 85.5%-ийг импортын, 14.5%-ийг дотоодын эх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч эзэлж байна.

Тайлант хугацаанд 03 дугаар сарын 13-ны 19:50 минутаас 3 дугаар сарын 17-ны өдрийн 00:40 минутын хооронд Увс аймагт тулгуур унаснаас үүдэлтэйгээр Баруун бүсийн эрчим хүчний системээс тэжээгддэг Тонхил, Дарив, Шарга, Төгрөг, Бугат сумд ЦЭХ-ний хязгаарлалтад, 03 дугаар сарын 14-ний өдөр 10 цаг 42 минутад Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнээс Тайшир гаргалгаа, 11 цаг 18 минутад Мөрөн-Тэлмэн гаргалгаа тасарч систем 0 зогсож, гэмтлийг "АУЭХС" ТӨХК-ийн цахилгаан шугам сүлжээний засварын бригад 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн шуурхай ажиллаж унасан тулгууруудыг сольж хэвийн байдалд оруулснаар Шарга, Төгрөг,

Бугат зэрэг сумдыг 3 дугаар сарын 17-ны өдрийн 00 цаг 30 минутад хүчдэлд холбож хэвийн горимд шилжүүлж хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангалаа.

Тайшир УЦС нь 2021 оны 03 дугаар өвлийн их ачааллын горимоор “Төвийн Бүсийн Эрчим Хүчний Систем”-тэй зэрэгцээ ажилласан.

Авто тээврийн үйлчилгээ: Тайлант хугацаанд 31 тээврийн хэрэгслээр Говь-Алтай-Улаанбаатар чиглэлд 403 зорчигч, Улаанбаатар-Говь-Алтай чиглэлд 208 зорчигч нийт 611 зорчигчид хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлсэн.

Техникийн хяналтын үзлэг: Тайлант хугацаанд нийт 392 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдлаа.

Агаарын тээврийн үйлчилгээ: Захиалгат 6, зорчигч тээврийн 2 удаагийн нислэгээр орон нутгаас явсан 482, ирсэн 508 иргэнд агаарын тээврийн үйлчилгээ үзүүлсэн байна.

“GG6-FLYGHT-TOUR” нэртэй байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтдыг сурталчилан таниулах, агаарын аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг боловсруулан Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлж, 03 дугаар сарын 20-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам тээврийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газрын холбогдох албан тушаалтнууд оролцсон цахим хурлаар хэлэлцүүлээ.

“Мэдээлэл Холбооны Сүлжээ” ТӨХК: Бигэр сумд хүчтэй шуурга холбооны хуучин цамхаг унасан тул инженер, техникийн ажилчид 3 дугаар сарын 22, 23-ны хооронд ажиллаж, Мобиком, Скайтел, Жи-Мобайл, Юнителийн антеннүүдийг шинэ цамхагруу зөөж, шилжүүлэн сүлжээнүүдийг сэргээж свич сольж хэвийн ажиллагаанд оруулсан.

“Жи-Мобайл” ХХК-ийн захиалгаар Тонхил сумын Дарцаг Уул сайтад релейны гэмтлийг, “Юнител” ХХК-ийн захиалгаар Баян-Уул сумд ажиллаж сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

Авто зам, замын байгууламжийн засвар арчлалт: “Говь-Алтай АЗЗА” ТӨХК нь А-1104 Алтай-Бургастай, А0303 Алтай-Баянхонгор, А1103 Алтай-Улиастай, А-0303 Алтай-Ховд чиглэлийн авто замын байгууламжийн зам арчлалтын ажлыг гүйцэтгэлээ.

ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

НҮБ-ын хүүхдийн сангийн Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх, “Бага насны хүүхдийн хөгжил” сургагч багш бэлтгэх болон Улсын гуравдугаар төв эмнэлэгтэй хамтран Дотрын өвчний сувилахуйн тусламж үйлчилгээний цогц шийдэл, уушигны гуурсны арчилгаа, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой гарсан тохиолдлыг бүртгэх мэдээлэх, дүн шинжилгээ хийх” цахим сургалтуудад давхардсан тоогоор 107 албан хаагч хамрагдан, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй гэрийн халаалт дулаалгын багцад хамрагдсан тус аймгийн 3 сумын 50 иргэн болон ажлын хэсгийн 50 албан хаагчид "Агаарын бохирдол эх хүүхдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх" талаар сургалт зохион байгуулан чадавхжууллаа.

Төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтад хамрагдан багц цагаа биелүүлсэн 7 эмнэлгийн мэргэжилтний материалыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүллээ.

Мөнгөн усны тухай минаматагийн конвенц ба бичил уурхай сургалтад хамрагдаж Алтны бичил уурхайн, үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх салбар дундын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын эрүүл мэндийн байгууллагуудын тендерийн 2021 онд хэрэглэгдэх 12 нэр төрлийн 24.7 сая төгрөгийн тарилгын шингэн татан авч, ашиглаж байна.

НҮБ-ын Хүүхдийн сангийн 72.0 сая төгрөгийн санхүүжилтээр 3 сумын Эрүүл мэндийн төвийн автомашинд бэхэлгээ, доторлогоо хийн, гэмтлийн бүх төрлийн чиг, яаралтай тусламжийн амьлуулах суурь тоног төхөөрөмжөөр тоноглолоо.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу байгууллагын шатахуун, тослох материалын тендерийг цахимаар зарлан, гүйцэтгэгчээр НИК ХХК шалгаран, гэрээ байгуулан ажиллаж байна.

3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гэрийн ажиглалтад 280 иргэн байна. Эрүүл мэндийн газар- зөвлөгөө пэйж хуудаст эрүүл мэндийн 259 зөвлөгөө, зөвлөмж мэдээ, мэдээлэл байршуулж 3357 хүний хандалт хийж мэдээлэл авсан байна.

Алтай мэдээ агентлагийн цахим хуудаст 63, монцамэ агентлагт 8, нийт 71 мэдээ байршуулж, давхардсан тоогоор 15987 иргэн хандалт хийж, мэдээлэл авсан байна.

Миний нутаг болон Алтай телевизид 5 удаагийн мэдээ, 2 төрлийн шторк, Монцамэ агентлагт 8 мэдээ, Алтай радиод 4 удаагийн цаг үеийн мэдээлэл өгч, иргэдийг мэдээллээр ханган ажиллалаа.

Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Эмчээ сонсьё” хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгт төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 150 эмч, эм зүйч оролцон, эрүүл мэндийн өнөөгийн байдал болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар саналаа солилцлоо.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Монгол Улсын Засгийн Газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран зохион байгуулсан “ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАХИМ ГҮЙЛТ-2021” арга хэмжээ 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс 28-ны өдрүүдэд улс орон даяар зохион байгуулагдлаа. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх, дархлаагаа дэмжих зорилгоор зохион байгуулагдсан тус арга хэмжээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн STRAVA апплейкшин ашиглан явуулсан бөгөөд манай аймгийн хувьд 14 хоногийн турш 3825 иргэн буюу хүн амын 6%-ийг хамруулан 89645 км замыг туулсан амжилтаар улсын хэмжээнд ТЭРГҮҮН байр эзэллээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр: 2021 оны 03 дугаар сард аймгийн хэмжээнд нийт 924 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгэлтэй байгаа ба 24 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан байна.

Ажлын байрны захиалга, зуучлал: “Хан Алтай ресурс” ХХК нь Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаатай

холбоотойгоор 26 мэргэжлийн 121 ажлын байрны захиалга ирүүлж, 131 иргэний ажилд орохыг хүүсэн материалыг хүлээн авч тус компанид хүлээлгэн өгч, зуучиллаа.

Мөн 9 байгууллагаас 138 ажлын байрны захиалга ирснийг зуучлан ажлын байрны шаардлага хангасан 21 иргэнийг санал болгон материалыг хүргүүллээ.

Нийгмийн халамжийн сангийн мэдээлэл: Нийгмийн халамжийн сангийн 2021 оны 03 дугаар сарын санхүүгийн мэдээг гарган ХХҮЕгазарт хүргүүллээ. Цахим Монгол хөтөлбөрийн хүрээнд төрөөс иргэдэд үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж байгаатай холбогдуулан ашиглахгүй болсон арилжааны банкны дансуудыг хаасан болно. Тайлант хугацаанд Нийгмийн халамжийн сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр 274 иргэнд 80.9 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1047 иргэнд 92.6 сая, амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 368 иргэнд 62.0 сая, ахмад настны хөнгөлөлт тусламж 26 иргэнд 3.8 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 66 иргэнд 1.8 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг тус тус үзүүллээ.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 03 дугаар сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа.

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 8623 хүнд 3190.9 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгосон өндөр настан 38, тахир дутуу 5, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 5 нийт 48 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

2021 онд нийгмийн даатгалын хуульд орсон өөрчлөлт, мөрдөгдөж буй хувь хэмжээний талаар “Говь-Алтай Нийгмийн даатгалын хэлтэс” facebook, page хуудсаар дамжуулан мөн НДЕГазрын тавигдсан боршур гарын авлагыг шэйр хийн иргэдэд түгээн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 81 иргэнд 126.8 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 42 иргэнд 6.3 сая, оршуулгын тэтгэмж 10 иргэнд 10.0 сая, ажилгүйдэлийн тэтгэмж 23 иргэнд 20.5 сая төгрөгийг тус тус олголоо.

Сайн дурын даатгалд нийт 113 хүн хамрагдсанаас 83 иргэн ажилгүй, 30 эх 0-3 насны хүүхдээ асарч байна.

Эрүүл мэндийн даатгалд 442 иргэнийг хамруулж 22.7 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 194 хүн орсноос шинээр 23 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 134 хүний групп сунгагдаж, 37 хүнийх цуцлагдлаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: Төрийн бодлого, шийдвэрийг танилцуулах, хамтарсан баг, хүүхэд хамгааллын багийн гишүүдийн хуулиар хүлээсэн чиг үүргийг таниулах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтад Есөнбулаг сумын шинээр сонгогдож томилогдсон багийн Засаг дарга нар

болон хамтарсан баг, хүүхэд хамгааллын багийн гишүүд, нийт 106 иргэн оролцон чадавхжлаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон Орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан “Ээжүүдээ сонсьё”, “Аавуудаа сонсьё” хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулж, 295 хүүхэд хамрагдаж, мэдээлэл авлаа.

Австрали төгсөгчдийн холбоо, Зориг сан, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Насан туршийн боловсролын төв, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Дэлхийн зөн ОНГ-тай хамтран мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжил сонголтын ментор хөтөлбөрийг ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж хөтөлбөрийн 1,2-р шатны сургагч багшийн цахим сургалт зохион байгуулагдлаа.

Хүүхдийн эрх, сурган хүмүүжүүлэх ухааны зарчимд суурилсан хүмүүжлийн эерэг аргын үзэл санааг гэр бүлийн хүрээнд хэрэгжүүлэхэд эн тэргүүнд шаардагдах мэдлэг, чадвар эзэмших, хүүхэдтэйгээ харилцах арга хандлагаа өөрчлөхөд эцэг эхчүүдэд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтыг Есөнбулаг сумын зорилтот бүлгийн 113 эцэг эхийг хамруулан зохион байгуулж, мэдээлэл хүргэн, чадавхжууллаа.

“Дэлхийн мөнгөний 7 хоног 2021” аяны нээлтийг 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, өсвөр насны 7-12 ангийн нийт 100 сурагч хаирагдан, санхүүгийн мэдлэг боловсрол олгох, хуримтлал, хувийн санхүүгээ хэрхэн удирдах зэрэг олон талын ойлголт мэдлэгтэй боллоо.

Байгууллагын цахим хуудаст 15 удаагийн видео, постер байршуулж 1639 хүнд мэдээлэл хүргэж ажиллалаа.

Энэ сард хүүхдийн тусламжийн 108 дугаарын утсанд 9 дуудлага ирсэн бөгөөд дуудлагын дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж, хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 1 дуудлага хааж 8 кейс дээр хариу үйлчилгээг хамтарсан багтай хамтран үзүүлж байна. Хамтарсан багийн гишүүдийн шинэчилсэн судалгааг нэгтгэн авч, дүгнэлт хийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүллээ.

Боловсрол, соёл урлагийн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2021 оны А/68 дугаар захирамжаар сургууль, цэцэрлэгийн орчмын бүсэд эрсдэлийн үнэлгээ хийж ажиллалаа. Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэгт БСУГ, Эрүүл мэндийн газар, Аймгийн онцгой комисс, Мэргэжлийн хяналт, Есөнбулаг сумын захиргааны төлөөлөл хамтран хийлээ. Эрсдэлийн үнэлгээгээр шаардлага хангаагүй цөөн сургуульд зохих шаардлагыг хүргүүлэн дахин үнэлгээ хийж сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг эхлүүлээд байна. Аймгийн хэмжээнд нийт сургууль, цэцэрлэгийн эрсдэлийн үнэлгээний дундаж гүйцэтгэл 84.4 хувьтай үнэлэгдсэн байна.

Танхимын сургалт 3 дугаар сарын 1-нд эхэлсэнтэй холбогдуулан аймгийн 5 сургууль, 10 цэцэрлэгийн хичээл эхлэх явцтай танилцаж гарч буй хүндрэл бэрхшээл, хичээл эхлэх бэлэн байдал, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, ирцийн мэдээлэл зэрэгтэй танилцан, зөвлөгөө чиглэл өгч ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуульд нийт хүүхдийн 91.2 хувь нь танхимын хичээлдээ хамрагдаж, 119 хүүхэд түр гэрийн тусгаарлалтад байна. Сургуулийн өмнөх

боловсролын нийт хүүхдүүдийн 45.3% нь танхимаар хамрагдаж бусад хүүхдүүд нь отор нүүдлээр явж байгаа малчид, эрүүл мэндийн үзлэгээр цагаан хорхой илэрсэн, эцэг эхийн хүсэлтээр, халдвартай бүсээс гэрт нь хүн ирж тусгаарлалтад орсон зэрэг шалтгааны улмаас хүүхдүүд цэцэрлэгтээ хамрагдаагүй байна.

НҮБ-аас зохион байгуулж буй бага насны хүүхдийн хөгжил, төлөвшил, эрүүл мэнд, асаргаа халамж, хүүхэд хамгаалал, зохистой хоол тэжээлийн талаар мэдлэг, мэдээллийг эцэг эх, асран хамгаалагч нарт хүргэх, хэрэгжүүлэх арга зүйд суралцуулах, “Сургагч багш бэлтгэх” сургалтад Эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, цэцэрлэгийн аргазүйч, цэцэрлэгийн эмч, тогоочоос бүрдсэн 20 хүнийг хамруулан чадавхжууллаа.

12 дугаар ангийн математикийн хичээлээр Функц ба график бүлэг сэдвийн агуулгаар аймгийн математикийн багш нар видео хичээл, бие даан бодох бодлогын жагсаалт, өөрийгөө сорих даалгаврыг анхан, дунд, ахисан шатлалаар бэлтгэн ажиллаж байна. Энэ хичээлийг Боловсролын хүрээлэнгийн цахим хаягт байршуулан ажиллаж байгаа нь улсын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар хийж байгаа нэг онцлог ажил юм.

Дизайн технологи, дүрслэх урлаг, зурагзүйн багш нарт “Үнэлгээний шалгуур, суралцахуйн зорилтын талаар” онлайн сургалтыг зохин байгуулж, 51 багш оролцлоо.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад чадавхжуулах” сэдэвт зайн сургалт, тусгай хэрэгцээт сургалтын төвийн зохион байгуулсан сургалт, Монголын Тусгай Олимпийн Хорооноос зохион байгуулсан оюуны бэрхшээлтэй хүүхдийн дасгалжуулагч багш бэлтгэх сургалтуудад холбогдох 30 албан хаагч оролцон чадавхжлаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэлд 615 хүүхэд бүртгүүлээд байна.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Дэлхийн ойн болон усны өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ.

Дэлхийн ойн болон усны тэмдэглэлт өдрийг тохиолдуулан “Унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төсөл”-тэй хамтран Эрдэнэ, Чандмань, Цогт сумдад ажиллаж, ой, усны талаарх экологийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, нөлөөллийн арга хэмжээг 500 гаруй сурагчийг хамруулан зохион байгууллаа.

Мөн дэлхийн усны өдрийг “Усны үнэлэмж, үнэ цэнэ” уриан дор тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээний үеэр хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох 7 байгууллагын албан хаагчид оролцлоо.

Аймгийн Боловсрол соёл урлагийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран 12 сумын 7 цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд “Усны үнэ цэнэ” видео мэдээлэл, ерөнхий боловсролын 12 сургуулийн дунд ангийн 2517 сурагчдад “Цэвэр, бохир усны үйлчилгээ хэрэглэгч танд хэрхэн хүрдэг вэ? Дэлхийн усны нөөц” видео хичээлийг үзүүлж, усны зүй зохистой хэрэглээний талаар тодорхой мэдлэгтэй болголоо.

НҮБ-ын Хүүхдийн сан болон Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газар сайн дурын ажилтнуудтай хамтран аймгийн төвийн гэр хорооллын ус түгээх 22 байрнаас ус авч

байгаа иргэдэд усаа зөв зохистой авах, усны картын ашиглалт, усны хуванцар савны хэрэглээний талаар 700 гаруй материал тарааж, нөлөөллийн ажлыг хийлээ.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Алтай Соёны бүсийн салбар бүсийн зорилтот сум болох Халиун, Төгрөг, Шарга, Дарив, Тонхил, Хөхморьт, Баян-Уул сум, “Унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь” төслийн зорилтот Чандмань, Эрдэнэ, Цогт сумдад 20 булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг хийх бөгөөд техникийн даалгаврыг эргэлтийн цэг бүрээр нарийвчлан гаргаж боловсрууллаа.

Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг хийлээ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”, аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны А/652 захирамжийг хэрэгжүүлэн аймгийн хэмжээнд /18 сум, 2 тосгон/ агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл, тооллогыг зохион байгууллаа. Тооллогын дүнг авч үзвэл:

2020 оноос 15 квт хүчин чадалтай зуух 1826-аар буурсан, 15-100 квт хүчин чадалтай зуух 24-өөр буурсан, 101-ээс дээш квт хүчин чадалтай зуух 52 бүртгэгдсэн байна. Мөн машин, мотоцикль зэрэг хөдөлгөөнт эх үүсвэр 5502-оор нэмэгдсэн байна.

Аялал жуулчлалын чиглэлээр: Тус аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийн ажлын даалгаврыг боловсруулан зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа зарлаад байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Жаргалан сумын Хүнхэр-Эрээн нуур, Тайшир сумын Гэгээн нуур чиглэлийн аялал жуулчлалын цогцолборын авто замын техник эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын 03 дугаар сарын 17-ны А/104 дүгээр захирамжаар байгуулагдан ажиллаж байна.

Уул уурхайн чиглэлээр: Уул уурхайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг 2021 оны 3-р сарын байдлаар гарган 18 сумын Засаг даргад хүргүүллээ.

Алтны бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээнээс үүдэлтэй хор хөнөөлийг таниулах, мөнгөн усны хэрэглээг хязгаарлах хориглох зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Planet Gold” төрийн бус байгууллагаас “Минаматагийн конвенц ба бичил уурхай” сэдэвт цахим сургалтыг 3 дугаар сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Тус сургалтад аймгийн ЗДТГ, МХГ, БОАЖГ, Есөнбулаг сумын ЗДТГ болон аймгийн бичил уурхай эрхлэгчид оролцож, чадавхжлаа.

НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Боловсрол, соёл, эрүүл мэнд, хүнсний чанар, эрүүл ахуйн хяналтын хүрээнд:

Хүнсний чанарын хяналтаар: Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний худалдааны 16, хоол үйлдвэрлэлийн 8, хүнсний үйлдвэрийн 5 газарт хяналт шалгалт хийж нийт 106 зөрчил илрүүлэн 42 буюу 39.2%-ыг газар дээр нь арилгуулан бусад зөрчлийг арилгуулахаар 2 төрлийн хугацаатай зөвлөмж өгч, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Алтай хотын хүнсний худалдааны 23, хоол үйлдвэрлэлийн 4, хүнсний үйлдвэрийн 1 газарт урьдчилан сэргийлэх шалгалт хийж нийт 86 зөрчил илрүүлэн 42 буюу 48.8%-ыг газар дээр нь арилгуулан, 43 ажилтад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч 4 төрлийн гарын авлага материалыг түгээн, мэдээллээр ханган ажиллалаа.

Эм биобэлдмэлийн хяналтаар: Аймгийн 4 эм ханган нийлүүлэх төв, 13 эмийн сан, 7 эмнэлэг, 2 сумын Эрүүл мэндийн төвийг хамруулан мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтын байдалд шалгалт хийхэд 32 зөрчил илэрч, 13 байгууллагад 32 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар: Воко дент, Анар дент, Халиун шүдний үүдэн эмнэлэгт хяналт хийн ардас, агаар, ариун материалын сорьц авч Нэгдсэн лабораторид шинжлүүлж байна.

Ундны усны 24 дээж авч Нэгдсэн лабораторид шинжлүүлэхэд 9 дээж магнийн хатуулгийн хэмжээгээрээ стандартаас их дүнтэй гарсан тул улсын байцаагчийн дүгнэлт гарган хүргүүллээ.

Коронавируст халдвараас сэргийлэх зорилгоор агаарын тээврээр зорчсон зорчигчдын эрүүл мэндэд тандалт судалгаа хийж ажиллалаа.

Байгаль орчин, уул уурхай, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтаар: Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 3 аж ахуй нэгжид хийж, 30 заалттай 3 албан шаардлага хүргүүлэн, дулаан хангамжийн үйл ажиллагаа эрхэлж буй 1 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийгдэж байна.

Цар тахлын байдалтай холбогдуулан хяналт шалгалтад хамрагдсан 4 аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж, 72м² талбайд халдваргүйтгэлийг хийлгүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Иргэн Н. Баярмаагаас ирүүлсэн өргөдлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 143.0 мянган төгрөгийн цалин хөлсийг олгуулж, 857.9 мянган төгрөгийг ажил олгогчоос нөхөн төлүүлэхээр акт тогтоож, 100% барагдууллаа.

Барилгын техникийн хяналтаар: 3 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, улсын байцаагчийн 3 дүгнэлт үйлдэж хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хэмжилзүйн хяналтаар: Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн хамтарсан 10 заалттай 1 албан шаардлага өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

МХЕГ-ын 18-р тушаалын дагуу тус сумд үйл ажиллагаа явуулж буй 22 аж ахуйн нэгжид халдвар хамгааллын байдалд хяналт хийж, нийт 65 зөрчил илрүүлэн 25 зөрчлийг арилгуулсан ба арилаагүй зөрчилд хугацаатай үүрэг даалгавар өгч, 5 төрлийн 150 тараах материалыг хүргэлээ.

Байгаль орчин, газар геодези зураг зүйн хяналтаар: 1 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчигээ үзүүлж 8 заалттай 1 зөвлөмж хүргүүлж, 2 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ хийгдэж байна.

“Мандал голомт” ХХК-ийн 2-р халаалтын зуухны үйл ажиллагаанд шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгууллаа. Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу 5 иргэнд 1.8 сая төгрөгийн торгууль, 340.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр тооцож, барагдуулалт 90.0 хувьтай байна.

Нэгдсэн лаборатори: Лабораторид 6 аж ахуй нэгж, 2 иргэн, 5 байгууллагаас хүнсний бүтээгдэхүүний 10 сорьц 36 үзүүлэлт, ундны усны 16 сорьц 212 үзүүлэлт, эмнэлгийн ус 3 сорьц 9 үзүүлэлт, ариун 20 сорьц 20 үзүүлэлт, агаар 5 сорьц 15 үзүүлэлт, арчдас 60 сорьц 60 үзүүлэлтээр хими хор судлал, үр хорио цээр, нян судлалын шинжилгээг хийсэн. Үүнээс ундны усны 4 сорьц 7 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна. Шинжилгээний төлбөр 69300 төгрөгийг бүрэн төвлөрүүлээ.

ЕС. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОНЦЛОГ АЖИЛ:

Алтай сум: Сумын Засаг даргын захирамжаар Хэлний бодлогын салбар зөвлөлийг байгуулан, төрийн албан хаагчдын гарааны үнэлгээг тогтоож сургалтыг орж эхлээд байна.

Сургууль цэцэрлэгийн хичээл сургалт эхэлсэнтэй холбоотой Эрсдэлийн үнэлгээг хийх ажлын хэсгийг томилон ажиллуулж, Цэцэрлэг бага эрсдэлтэй, сургууль, дотуур байр эрсдэлтэй үнэлгээ авч, эрсдэлгүй байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэл өглөө.

Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярыг тохиолдуулан Соёлын төвийн хамт олноос “Цэргийн дуу”-ны цахим уралдааныг зохион байгуулж 14 хүн оролцож, дүнгээ гаргалаа.

Цахим гүйлт арга хэмжээнд сумын нийт 7 байгууллагын 315 иргэн 1150 км гүйж, эрүүл мэнддээ болон аймгийн үзүүлэлтэд хувь нэмрээ орууллаа..

Баян-Уул сум: Монгол хэл бичгийн сургалт зохион байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 03 дугаар сараас эхлэн байгууллагын албан бичгийг кирил, монгол бичиг хослосон хэлбэртэйгээр ашиглаж эхэллээ.

Цахим гүйлт арга хэмжээнд сумын нийт 304 иргэн 2800 км гүйж, эрүүл мэнддээ болон аймгийн үзүүлэлтэд хувь нэмрээ оруулсан бөгөөд цаашид үйл ажиллагаа үргэлжлүүлж байна.

Сумын Соёлын төвөөс Ээжийн тухай дууг хэн сайн дуулах вэ?, "Ээждээ өргөх дуун цацал", "Нутгийн сүлдэндээ өргөх дуу", "Штабын дарга" дууг хэн сайн дуулах вэ?, "Эрийн хийморь" цэнгээнт уралдаант цахим нэвтрүүлгүүдийг бэлтгэн давхардсан тоогоор 41 уран бүтээлч оролцож, 7810 хүн үзэж сонирхон, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөсөн байна.

Бигэр сум: Тус сумын хэлний бодлогын салбар зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, сургалтын үйл ажиллагааг эхлүүллээ.

2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн багийн Засаг даргын сонгуулийн үр дүнд шинээр багийн Засаг даргаар томилогдсон 5 багийн Засаг даргад батламж гардуулан сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад багийн Засаг дарга нарын үүрэг, оролцооны чиглэлээр сургалт зохион байгуулж, удирдлагууд үүрэг чиглэл өглөө.

Шуурганы улмаас хашаа унасан-52, гэр унасан-11, цагаан бүрээс урагдсан- 6, амбаар, байшин, барилгын дээвэр хууларсан-16, машины шил хагарсан-6, дарагдаж үхсэн мал-6, шуурганд уруудсан олдоогүй байгаа -150 орчим мал байна.

Урьдчилсан байдлаар төрийн байгуулагад-3522.0 мян төгрөг, аж ахуйн нэгж-д 526.0 мян төгрөг, иргэнд- 13997.0 мян төгрөгийн хохирол учирсныг тогтоолоо.

█

Бугат сум: Тус сумын сургууль “Монгол бичигтэн хамт олон” аян өрнүүлэн ажиллаж байна.

Төрийн байгууллагын албан хаагчдаас “Монгол бичгийн түвшинг тодорхойлох” судалгааг гарган нэгтгэж “Монгол бичгийн хичээл”- д суух албан хаагчдыг 2 шат болгон хувааж, нийт 120 алба хаагч хамрагдаж байна.

Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн танхимын сургалт эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн анги, танхим, дотуур байранд мэргэжлийн байгууллагатай хамтран халдваргүйжүүлэлт хийж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх санамж зөвлөгөөг сургуулийн коридор, анги танхимд байршуулаж, эрсдлийн үнэлгээг хийж, цаашид анхаарах болон хийж хэрэгжүүлэх ажлын санал зөвлөмжийг гаргаж, эрсдлийг бууруулан ажиллаж байна.

Соёлын төвийн хамт олон Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах баярын өдөрт зориулсан “Ээждээ өргөх дуун цацал” ардын авьяастнуудын урлагийн тоглолтоо цахимаар үзэгч олондоо өргөн толилууллаа.

Есөнбулаг сум: Цахим гүйлт арга хэмжээг дэмжин эрүүл мэнддээ болон аймгийн үзүүлэлтэд хувь нэмрээ оруулж, нийт 1228.06 км гүйж хаалтын арга хэмжээнд оролцлоо.

Тус сумын Наран багийн иргэн Ч.Алтангэрэлийн хотонд ихэр ботго төрсөн нь энэ жилийн 2 дахь тохиолдол боллоо.

"Жимс жимсгэнэ" хөтөлбөр, СХСан, ЖДҮ-ийн зээлийн журам болон төсөл бичихэд анхаарах асуудлын талаарх сургалтыг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 88 иргэн оролцож, мэдээлэл, санал бодол, туршлагаа солилцлоо.

Жаргалан сум: Сумын хэлний бодлогын салбар зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж үндэсний хэл бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх, олон нийтэд сурталчилах, түгээн дэлгэрүүлэх ажлыг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж, ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Албан хаагчдын монгол бичгийн түвшинг тогтоон, сургалтын үйл ажиллагаа эхэлсэн.

Тайшир сум: Сумын Засаг даргын дэргэдэх Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 66 төрийн албан хаагчаас монгол хэл, бичгийн гарааны үнэлгээ тогтоох сорилыг авч, анхан болон дунд шатны хичээл сургалтыг эхлүүлээд байна.

7 хоног бүрийн Даваа гарагт төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар болон холбогдох мэргэжилтнүүд хийсэн ажлаа танилцуулж, ирэх 7 хоногт хийх ажлаа хэлэлцэж үүрэг чиглэл өгч ажиллаж хэвшлээ.

Шинээр томилогдсон багийн Засаг дарга нарт сургалт зохион байгуулж, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, статистик мэдээ гаргах, албан хэрэг хөтлөлт гэх мэт холбогдох 9 чиглэлээр мэдээ мэдээлэл хүргэж, үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Эерэг хандлагыг түгээх зориолгоор 03 дугаар сард "Талархлын сар"-ыг аяныг эхлүүлээд байна.

Үндэсний бичгийн сургалтыг төрийн албан хаагчдад зохион байгууллаа.

Дотуур байрын сурагчдын дунд тэдний эцэг эхтэй "Хариу мессеж" дэвтэр аялуулах, "Номоо эмчлэх" аян өрнүүлж, сурах бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах,

"Урам хайрлая " самбар ажиллуулах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулан, байрны сурагчдад эерэг хандлага, зөв хэвшлийг төлөвшүүлж байна.

Тонхил сум: Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаврын дагуу төрийн албан хаагчдаас Монгол бичгийн түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулж, анхан, дунд, ахисан түвшингээр нь 3 анги болгон 7 хоногт 3 удаа хийчээл орж хэвшлээ.

Халиун сум: Үндэсний бичиг соёлыг дээдлэх үйл ажиллагааны нээлт болж, бүх байгууллагуудад Монгол бичгийн хичээл зааж эхлэв.

“Өглөө” арга хэмжээг зохион байгуулж, 2021 оныг "Хариуцлага-Зарчим-Ёс зүйн жил" болгон зарлаж, жилийн ажлын нээлтийн үйл ажиллагааны нээлт болж, төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт "Ёс зүйн" дэвтэр болон хариуцлага-зарчим-ёс зүйн самбарыг гардуулан өгч, цаашид сахилга хариуцлага-зарчим, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэн, төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж ажиллах талаар чиглэл өглөө.

Цогт сум: Тус сумын Баянтоорой тосгонд үхсэн үхэр галзуу өвчнөөр өвчилсөн нь аймгийн Мал эмнэлгийн лабораториор батлагдаж 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоон 436 үхэр, 29 ямаа, 7 нохойд галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарьж, урьдчилан сэргийллээ.

“Цэмцгэр Цогт” хөтөлбөрийн хүрээнд жишиг гудамж бий болгох төслийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Цээл сум: Тус сумд үйл ажиллагаа явуулдаг 21 дэлгүүр, 4 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хаяг болон хэвлэмэл хуудсаа Монгол бичгээр хэвлүүлж албан хэрэгцээндээ ашиглаж хэвшүүлэх, хэрэгжилтийг ханган ажиллах тухай албан бичгийг хүргүүллээ. Төрийн байгууллагын албан хаагчид 7 хоног бүрийн баасан гарагт Монгол бичгийн хичээлд хамрагдан, нийт 96 албан хаагч суралцаж эхлээд байна.

Шарга сум: Үндэсний бичгээ олон нийтэд сурталчилах, түгээн дэлгэрүүлэх ажлыг 01 албан даалгаврын дагуу төлөвлөн байгууллагын нийт албан хаагчдыг хамруулан оролцож байна.

Монгол улсын хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрийг сурталчилан таниулах, хууль тогтоомжийн хэрэгжилт, баримт бичгийн стандартыг хангуулах, мэдээ тайлангийн чанарыг дээшлүүлэх зорилгоор шинээр сонгогдсон багийн Засаг дарга нар, иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт сургалт зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийг танилцуулж, мэдлэг чадварыг нь дээшлүүллээ. Мөн хугацаатай тайлан мэдээ, судалгаа, баримтлах эрх зүйн акт, журам зааврыг багтаасан гарын авлагыг бэлтгэж хүргэлээ.

“Дэлхийн зэрлэг амьтан, ургамлын өдөр”-ийн хүрээнд сургуулийн сурагчдын дунд “Ой, амьтан бидний амьдралд” сэдвийн хүрээнд чөлөөт сэтгэлгээнийбүтээл

ирүүлэх уралдааныг цахимаар зарлаж, 4 хүүхдийн бүтээлд гарын бэлэг дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

“Эрүүл мэндийн цахим гүйлт-2021” арга хэмжээнд байгууллага, хамт олон хорооллоороо нэгдэн оролцлоо. 78 иргэн стравад нэгдэж 1 өдөрт 1800-2423 км зам гүйж, эрүүл мэнддээ болон аймгийн амжилтад хувь нэмрээ оруулсан байна.

Эрдэнэ сум: Хэлний бодлогын салбар зөвлөлийг Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/30 дугаар захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 3 дугаар сарын 1-ний өдөр үндэсний бичгээ сурцгаах арга хэмжээний нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, албан хаагчдын Монгол бичгийн түвшинг тогтоон, анхан шатны 73, дунд шатны 44, нийт 117 албан хаагчид монгол бичгийн хичээл зааж байна.

“Эрүүл мэндийн цахим гүйлт-2021” арга хэмжээнд байгууллага, хамт олноороо нэгдэн оролцож, 6 байгууллагын албан хаагчид 2817.03 км зам гүйж, эрүүл мэнддээ болон аймгийн амжилтад хувь нэмрээ оруулсан байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

